

СУУТНЫГ ЗААВАЛ ФИЛОСОФИЧ ГЭХ ШААРДЛАГАТАЙ ЮУ?

Бунийханы Ц. Гомбосүрэн (Sc.D, профессор)

Б.Дагзмаа (Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим

ШУС, МУИС

Түлхүүр үгс: Өндөр гэгээний айлдвар, сургаалыг философи гэх оновчтой эсэх. Өндөр гэгээний “Адистэдийн дээдийг хайрлагч эх” бол буддын шашны зохиол мөн. Өндөр гэгээний “Маанийн гүн бүтээл” бол буддын шашны зохиол мөн. Өндөр гэгээний зохиосон соёмбо сүлд бол философийн биш, харин бэлгэдэлт бүтээл мөн. Өндөр гэгээний Сүмбэм бол бүхэлдээ буддын шашны бүтээл мөн.

Товч утга: Энэ өгүүлэлд Өндөр гэгээн Занабазарын зарим зохиол болон түүний бүтээсэн Соёмбо сүлдийг гүн ухааны бүтээл хэмээн зарим судлаач үнэлж байдагт философийн үүднээс товч шинжилгээ хийсэн болно. Гомбодоржийн Занабазар бол философи сэтгэлгээний үр дүнгээс хэтийдсэн буддын шашны сургаал, зарлиг айлдсан гэгээн хутагт хүн мөн гэсэн ерөнхий дүгнэлтэнд хүрсэн болно.

* * * * *

Өндөр гэгээн бол манай зарим зохиогч бичдэгээр буддын гүн ухааны нэг чиглэл хэтрүүлэгч төв үзлийг баримталдаг байсан аж. Гэхдээ философи үзлээ ил гарган сурталчилж, хөгжүүлсэн бүтээл нийтлүүлээгүй хүнийг “философич” гэж зарлах нь түүнийг өргөмжлөхөд заавал шаардагдах уу? гэдэг асуулт гарах талтай.

Уг нь гэгээнтний айлдсан зарлиг, ерөөл, уншлага, сургаалт үг зэргээс бүтсэн лав л нэг боть хэмжээтэй зохиол байдаг тухай олон жилийн өмнөөс бид зарим мөр уншиж, бас мэр сэр сонсож ирсэн юм. Тухайлбал, энэ тухай Зава Дамдин Лувсандаян гавж « “Их Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх. “Алтан дэвтэр” » гэдэг эдүгээ нэн үнэ цэнэтэй байгаа номондоо бичихдээ: «Богд гэгээний зарлиг ганц боть төдий байгаагийн учрыг Заяа бандида бээр “Сайн номлолыг туурвих нь үг утгын найруулга маш сайн байх боловч, зарлиглахдаа дээд төрөлхтөн лам нарын гайхамшигт зарлиг сургаал ийм олон байсаар атал, би мэт шинээр туурвиж үйлдэх ямар хэрэг байсан” хэмээсэн юм»¹ гэж эх орныхоо цаашдын хувь заяаны асуудалд түүхэн гүйцэтгэлтэй оролцох, шашин, сүм хийдийн толгой дээрээ буусан үйл хэргийг гүйцэлдүүлэх, бурхан бүтээх зэргээр өндийх завгүй амьдарч, ажиллаж байсан Өндөр гэгээний тухай бичсэнийг бид уншиж байв.

Харин аз ирэхэд Өндөр гэгээний бүтээлүүд төвд хэлнээс бүгд орчуулагдаад “Өндөр гэгээний сүмбүм” нэртэйгээр 2018 онд хэвлэгдсэн юм. Ингэснээр бид энэ илтгэлдээ алдаа гаргасан байлаа ч тэр нь эх сурвалжтай дутуу танилцсанаас болоогүй байж таарах нь.

Өндөр гэгээний бүтээлүүдийг манай зарим судлаач “философи (гүн ухаан)-ийнх” гэж үзэж байгаа билээ. Бид энэ илтгэлдээ үүнтэй холбоотой зарим тайлбар хийхийг зорьсон болно.

¹ Дурдан буй ном. УБ., 2014, 208 дахь тал

Нэг. Т.Булган “Маанийн гүн бүтээл”, Д.Гантөмөр “Маань бүтээх гүн увидас”, Д.Лувсанцэрэн “Маанийн гүн бүтээлийн арга”, Г.Мягмарсүрэн “Маанийн бүтээлийн гүн арга” гэх мэтээр орчуулсан Өндөр гэгээний зохиолд бичээч цорж Агваандорж (1785-1849)-ийн эзотерик тайлбарыг агуулгынх нь үүднээс бүрэн ухааж ойлгохгүй байгаа боловч ямар ч гэсэн гүн ухааны биш, харин буддын шашны үүднээс уг тайлбараа хийсэн гэж үзэж байгаагаар дурдья. “Маанийн гүн бүтээл” бол энэхүү цорж ламтны тайлбарласнаар «“Арьяабал бурхныг бясалган бүтээх арга билээ. Чухамдаа түүний бүтээх эрхэм дээд арга энэ болой гэдгийг ухааруулж мэдүүлэхийн тулд “Маанийн гүн бүтээл” хэмээн нэрлэжээ. Чингээд ч энэ үед энэхүү үесийн “гүн” хэмээх нь, очирт хөлгөн хэмээхийн “очир”-той утга нэгэн билээ. Тиймээс тарнийн ерөнхий ёсонд “Гүн, тодорхой” хоёр ялгалгүй чанарт бөгөөд ханьцашгүй дээдийн ёсноо ч “амгалан, хоосон хоёр ялгалгүй чанар нь”, маани, бадамыг магад утгатай нэгэн утгат (агаар нэгэн) гэж үздэг”»¹ хэмээн Цорж ламтан үнэлээд түүнээ дэлгэрүүлэн тайлбарласан байдаг.

Тэгвэл манай үеийн философич Г.Лувсанцэрэн “Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008” гэдэг нэртэй өгүүллүүдийн эмхэтгэл номондоо: “Өндөр гэгээн Занабазар Жагарын орны эртний хутагт мэргэдийн нэгэн адил ертөнцийн уг үндсийг байгаагаар нь ухааран барьж, түүнийгээ нэн товч бадаг, хэллэгээр нягтад хураан илэрхийлдэг байжээ”² хэмээсэн буй. Энэ ишилсэнд Занабазар бол хутагт үнэний цаад хязгаарт хүрснийг, өөрөөр хэлбэл тэрээр хоосон чанарыг онон барьсан гэгээнтэн мөнийг бишрэн дурджээ. Гэвч ингэж дурдсандаа залгуулаад: «Хутагт Занабазарын **гүн ухааны** ийм сэтгэлгээний нэгэн илрэл болсон бүтээл нь “Маанийн гүн бүтээлийн арга” зохиол юм» гэжээ. Тийнхүү тэрээр Өндөр гэгээний бүтээлд эхлээд өгсөн буддын шашны бишрэлт үнэлгээгээ гүн ухааны буюу үнэлэмжийн үнэлгээгээр, өөрөөр хэлбэл тодорхой нэг талбарт л хүчинтэй байдаг үнэлгээгээр сольжээ. Энэ сүүлчийн ишлэл дэх санаа нь маанийг тарнийн арга уддисаар биш, харин философиор, манай зарим нийтлэлч монголоор нэрлэдгээр бол гүн ухаанаар бүтээдэг юм гэсэн логик дүгнэлт рүү зарим уншигчийг хөтөлж байна.

Буддын гүн ухаанд “арга-билиг”, “амгалан”, “хоосон (чанар)” гэх мэт ойлголтууд байдаг тухай орчин үеийн зарим судлаачдын тайлбарт үнэмшил төрөхгүй байна. Ийм бодлоо үндэслэж “Маанийн гүн бүтээл”-ээс зарим мөр ишилье. Үүнд:

“Эс арилсан тийн мэдэл (сэтгэл) хоосон болсон орон дор

Арилсан мөн чанарын агаарт

Арга билиг хоёр үгүй хийгээд гэрлийн

Амгалан хоосон хослон орсон

Маани бадмэ-гийн магад утга”³ гэж тэнд буй. Бас тэнд:

“Билиг болбоос их хоосны туйл”⁴ гэжээ.

Зөвхөн эдгээр цөөн мөрнөөс ч гэсэн дүгнэлт хийхэд “амгалан мөн чанарын агаар”, “хоосон”, “билиг” зэрэг бол манай зарим эрдэмтдийн тайлбарладагчлан гүн ухааны категориуд гэхээс илүү гэгээнтэн, хутагт нар чинад (эзотерик) ертөнцийг жич жич хандлагын үүднээс онон барьсан (“танин мэдсэн” гээгүй) нь мөн байдаг.

¹ Т.Булган. Буддын философийн дэвтэр. УБ., 2010. Хавсралт (306 дахь тал)

² Дурдан буй ном, 91 дэх тал

³ Мөн тэнд

⁴ Мөн тэнд, 304 дэх тал

Хоёр. 2019 онд хэвлэгдсэн “1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал” гэдэг хамтын бүтээлд оруулсан нэг бүлэгтээ Ц.Гомбосүрэн бичихдээ «Р. Алтансүх, Б. Ариунзул нар 2016 онд “Өндөр гэгээн Занабазар. Адистэдийн дээдийг хайрлагч эх (орчуулга, тайлбар)” гэдэг ном хэвлүүлсэн нь монголчуудынхаа буддын шашны болон нийт соёлын сэтгэлгээнд буянтай үйл болжээ. “Адистэдийн дээдийг хайрлагч эх” болон гурван ч их эрдэмтэн ламын тайлбар зэргийг бүгдийг төвд хэлнээс орчуулан эмхтгэж хэвлүүлсэн энэ номондоо хоёр судлаач “Адистэдийн дээдийг хайрлагч эх”-ийн философийн зарим үзэл санаа” нэртэйгээр өөрсдийнхөө бичсэн...* өгүүллийг хавсарган оруулсан байна. Тэр өгүүлэл нь: “Өндөр гэгээн Занабазарын “Адистэдийн дээдийг хайрлагч эх” бол монголын буддын философийн нэгэн оргил бүтээл мөн. Уламжлалт тайлбаруудын... агуулгаас харахад буддын философийн их хөлгөний “цагийн хүрдний” ёсыг голлож, “цагийн хямрал” хэмээх ойлголтоор уламжлан нийгэм-ёс зүйн асуудлуудыг хөндсөн байх аж хэмээн эхэлсэн юм. Тэгээд... Богд Занабазар... “огторгуй түгээмэл”, “гурван цаг”, “орон зай”, “орчлонгийн хязгаар” гэдэг ойлголтууд болон билиг барамидын үндсэн үзэл санааг тусган, хэтрүүлэгч төв үзлийг үзэл санааныхаа тулгуур эх болгосон тухай хоёр зохиогч өгүүлэлдээ үндэслэн тайлбарласан байна»¹ хэмээн бичжээ.

Р.Алтансүх, Б.Ариунзул нарын тийм тайлбарт нь илтгэгч нар дараах онолын сэтгэгдэл илэрхийлье. Үүнд: нэгдүгээрт, Р.Алтансүх, Б.Ариунзул нарын зүгээс философи утгатай гэж тайлбарлаад байгаа, дээр заримыг нь дурдсан цөөн биш ойлголт, үндэслэлүүд болбоос буддын шашны мэдлэг юм. Бас Р.Алтансүх, Б.Ариунзул нар зохиолыг нь номондоо хавсралт болгож хэвлэсэн Лувсанняядаг, Агваанхайдав, Цэрэнжав нарын эрдэмтэн лам нар “Адистэдийн дээдийг хайрлагч эх” зохиолыг гүн ухааны үүднээс биш, харин шашны уншлага, залбирлын бүтээл мөнхий нь хувьд, тарнийн ёсны дагуух эзотерик санаа агуулсан тийм мэдлэгийнх нь хувьд тайлбарлажээ. Авралын орон, долоон гишүүнт (тахил), адистэд, номын сахиус, багш, төгс жаргалан, хувилгаан лагшин, бясалгал, ядам, ядам болгох ёс, хоосон чанарын агаарт одогч, гурван үүдний нэг бишрэл зэрэг буддын шашны мэдлэг дэх (ойлголт төдий биш, харин далд, чанад ухамсарын мэдээнүүдийн) санаа “Адистэдийн дээдийг хайрлагч эх”-д шингэснийг Лувсанняядаг, Агваанхайдав, Цэрэнжав нар нотлон тайлбарласан байна.

Хутагт Занабазарын энэ бүтээлд Р.Алтансүх, Б.Ариунзул нар хамааруулаад буй буддын гүн ухааны зарим үзэл болбоос Өндөр гэгээний “Сүмбүм” эмхэтгэл номонд байхгүй байгаа.

Гурав. Б.Даш-Ёндон 2015 онд Л. Мөнхбаатартай хамтран бичиж хэвлүүлсэн “Соёмбо сүлд-монгол ухаан” гэдэг номондоо монголчуудынхаа төдийгүй хүн төрөлхтний оюуны сан, ард түмнийхээ үндэсний тусгаар тогтнолын төлөө үзэл санааг хамгаалан бататгах хувь заяат үйлс зэрэгт Өндөр гэгээн өөрийн цогцлоон бүтээсэн Соёмбо сүлднийхээ бэлгэдлүүдэд шингээсэн дээд гэгээн үзэл санаануудаараа чандмань эрдэнэн хувь нэмэр оруулж ирсэн түүхтэй ба эдүгээ ч оруулж байгааг илэрхийлжээ. Хоёр зохиогчийн ийм шинжилгээний ач холбогдолыг бид үгүйсгэх гээгүй. Харин тэдний өөр дүгнэлтэнд саналаа илэрхийлэх юм. Үүнд, энэ хоёр зохиогч номныхоо дотор хавтсанд

* Энэ 3 цэгийн зайнд “болсон” гэдэг үг яагаад ч юм бэ орчихсон, тэр алдааг анзааралгүй хэвлэчихжээ. Энэ нь хоёр зохиогчийг бассан юм шиг утга бий болгож байгаа нь тэднээс далимыг ашиглан уучлалт хүсэх бололцоог Ц.Гомбосүрэнд олгож байна.

¹ Дурдан буй ном, 375-376 дахь тал

хэвлүүлсэн танилцуулгандаа бүтээлийнхээ зорилгыг: “манай Монголын Занабазар... дэлхийн гүн ухаан, философийн түүхэнд орохгүй гээгдэж боломгүй хэмээн нотлохыг оролдсон болой” гэж дурджээ. Тэд бүтээлийнхээ зорилгыг ийнхүү томъёолохдоо “гүн ухаан”, “философи” гэдэг хоёр үгийг нэг дор зэрэгцүүлэн бичсэн нь тэдний номон дотор заримдаа ижил, заримдаа ялгаатай утгатай юм. Энэ илтгэлд ижил утгыг нь үндэс болгов.

“Занабазарын Соёмбын гүн ухаан зөвхөн эерэг талаасаа уншигдах утгатай амой” гэж бичсэнийг философи үндэстэй зарим шалтгааны улмаас дагах сэтгэл илтгэгч нарт төрөхгүй байна. Нэгдүгээрт, соёмбыг монголын хүн ам бүгдээрээ эерэгээр хүлээж авлаа гэхэд монгол биш үндэстнүүд дотор сөрөг талаас хүлээж авах хүмүүс гарахыг бид хорихын төлөө байх ёстой юу? Хоёрдугаарт, Соёмбо өөртөө дэлхийн түүхэн философиудын охь шимийг шингээсэн гэж хоёр зохиогч үнэлжээ. Хэрэв тийм бол Соёмбыг онол, сургааль гэж таарна. Гэтэл энэ номын хавсралтанд “...ард түмний сэтгэл гэдэг нь түүний гүн ухаан, ёс суртахуун болой. Соёмбо үүнийг илэрхийлж байна” гэжээ. Хэрвээ соёмбо титэмийг энэ дурдсан утгаар “гүн ухаан” гэж үнэлж буй бол доктор Б.Даш-Ёндонгийн ийм үнэлгээ нь философи онолынх биш, харин ерийн ухамсрынх юм. Гэхдээ энэ үг бол ерийн ухамсрын мэдлэгийг буруутгах, дорд үзэх бодлын илэрхийлэл биш юм. Зарим үйлдлийг хийхэд философи буюу гүн ухааны онол биш, харин ерийн ухамсрын мэдлэг зүйрлэшгүй ашиг өгдөг нь ойлгомжтой. Гуравдугаарт, хэрэв Соёмбыг философи гэх юм бол Монголын Соёмбо сүлд зөвхөн холбогдох нөхцөлдөө л эерэг байж, бусад нөхцөлд хүчинтэй байж чадахгүй гэж мэргэжлийн төвшинд үзэх ёстой. Дөрөвдүгээрт, Соёмбо титэмийг гүн ухааны онол буюу философийн онол гэж үзвэл хэдэн арав, зуугаар тоологддог тэдгээр сургаалын аль нь, эсвэл аль хэд нь соёмбо сүлднийх вэ?, эсвэл соёмбо сүлд өөрийн гэсэн философитой юу гэсэн асуулт гарах үндэстэй. Гэтэл Өндөр гэгээний “Сүмбүм”-д философийн гэх зохиол байхгүйг өмнө дурдсан билээ.

Хэрэв Соёмбо сүлдийг философи гэж үзвэл тэр нь ертөнцийг үзэх үзэл, ёс суртахууны номлол зэргээрээ ялгаатай философиудтай ямар харьцаатай вэ? хэмээсэн баймгүй гэнэн ч гэсэн асуулт гарах тохиолдолд түүнд хоёр зохиогчийнх нь хариулт болохоор тайлбар “Соёмбо сүлд: монгол ухаан” номонд байгаа. Номын зохиогч нар бичихдээ: “...Соёмбо титэмийн бэлгэдлүүдийн агуулга нь Лаоз, Күнз нарын дундад үзэл, Аристотелийн дундажийн онол, ахуй-юу ч биш (хоосон чанар)-тогтнохуйн гурван эшний тухай Гегелийн баримтлал, К. Марксын диалектич үзэл зэрэг лүгээ очиж авцалдаж байна гэдгийг л хэлэхээр хязгаарлая” гэсэн буй. Ингэж бичсэнд нь зарим шүүмжлэлт санаа хэлье.

Лаоз, Күнз, Аристотель нарын сургаальд “дунд” гэсэн язгуур орсон үгээр илэрхийлдэг философи үзэл байдаг ч тэд ертөнцийг үзэх үзэл, нийгмийн зориулалт зэргээрээ бие биеийнхээс ялгаатай философи бүтээсэн билээ.

Энэрэх сэтгэл, эв нэгдлийн үзлийг өөртөө шингээсэн хэмээн дээдэлж сурталчилсан соёмбо сүлдийнхээ бэлгэдлүүдийг Гегель бүтээж, Маркс баримталсан диалектиктэй авцалддаг гэж хоёр зохиогч бичжээ. Гэтэл германы энэ хоёр философич эсрэг тэсрэгүүдийн тэмцэл туйлын, харин тэдгээрийн нэгдэл харьцангуй гэж сурталчилсан. К. Марксын онол арга зүйгээр зэвсэглээд ангийн тэмцэл, пролетарийн хувьсгал ба пролетарийн диктатурын тухай хүчирхийллийн сургаал боловсруулж, уг сургаалын албадан хэрэгжилт нь XX зуунд хүн төрөлхтөнд ямар хөнөөл учруулсныг бид мартаж, үл хайхрах байдал гаргаж болохгүй.

Танин мэдэхүйн үүднээс хандвал Өндөр гэгээний бүтээсэн соёмбо сүлд бол тэмдгэн бэлгэдэл билээ. Харин философи бэлгэдлийн бүрдлүүдийг өөртөө шингээдэг талтай ч бүхэлдээ бол тэр бэлгэдэл нь ганц зэрэг цөөн өгүүлбэр юм уу, бэсрэгхэн зохиол (текст) байдаг. (Ф.Ницше бэлгэдэлт зохиолын анхны том мастер байх). Философийг бүхэлд нь бэлгэдэл гэх учиргүй нэг үндэслэгээ дурдахад францын философич Ж.Лакан “бэлгэдэл бол юмны алуур мөн” гэдэг томъёолол боловсруулаад түүнээ үндэслэж тайлбарласан байдаг.

“Соёмбо сүлд бол философи (гүн ухаан) мөн” хэмээсэн Б.Даш-Ёндон эрдэмтний үзлийг дагахгүй байгаа нь нийгмийн философийн салбарт, түүний дотор улс төрийн философийн салбарт, бас дэлхийн түүхэн ба орчин үеийн чухал чухал философийн бүтээлийг орчуулан сурталчлах үйл ажиллагаанд чухал гавъяатайг үгүйсгэдэг байдал биш ээ.

НОМ ЗҮЙ

1. Өндөр гэгээний сүмбүм. Орч. Г. Мягмарсүрэн. УБ., 2018
2. Өндөр гэгээн Занабазар. Адистэдийн дээдийг хайрлагч эх (орчуулга, тайлбар). Төвд хэлнээс орчуулж тайлбар хийсэн: Р.Алтансүх, Б.Ариунзул. УБ., 2016
3. Өндөр гэгээн Занабазар. Маанийн гүн бүтээл. Орч. Т.Булган.- Т.Булган. Буддын философийн дэвтэр. УБ., 2010. Хавсралт (303-305дахь тал)
4. Зава Дамдин Лувсандаян. Их Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх “Алтан дэвтэр”. УБ., 2014
5. Бүдрагчаагийн Даш-Ёндон, Лхагвын Мөнхбаатар. Соёмбо сүлд-Монгол ухаан. УБ., 2015
6. Г.Лувсанцэрэн. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008
7. Өндөр гэгээн Занабазар. Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 1998
8. Лхамсүрэнгийн Хүрэлбаатар. Огторгуйн цагаан гарди. УБ., 1996, 31-32 дахь талд
9. Л.Хүрэлбаатар, Г.Жамсранжав. Монголын найман Богд. УБ., 2010. I Богд.

ABSTRACT

Authors have analyzed some researchers' conclusion, which argues “The method to achieve profound level of siddhi of Mani” and “Supreme blessing” by Undur Gegeen (High Holiness) Zanabazar as a philosophical literature. Authors have concluded that the researchers' interpretation implying philosophical account of Undur Gegeen is not as they claim to be and these arguments are actually those researchers' own philosophical explanation. Furthermore, author denies Soyombo script created by Undur Gegeen as a philosophy and demonstrates Soyombo script as a symbol.

At the end of the article, arguing Undur Gegeen is not a philosopher (value theorist) does not damages his reputation as a “Holiness”. In addition, if philosophical arguments are revealed from Undur Gegeen's work, author will gladly and respectfully study that philosophical perspective as an aspect of Undur Gegeen's manifoldness activity.